



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: [info@mojha.gov.mn](mailto:info@mojha.gov.mn),

Цахим хуудас: [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn)

2025.02.27 № 1/1224  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.НОМИНЧИМЭГ ТАНАА**

Таны “Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар” 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 08 дугаартай асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн,



**О.АЛТАНГЭРЭЛ**

151601153  
А5.файл.2025

गिराफ्तारी का इतिहास

गिराफ्तारी का इतिहास

गिराफ्तारी का इतिहास

गिराफ्तारी का इतिहास

[illegible]

ဗာ/ ဂုဏ်သိက္ခာ/ ဗာ/ ဂုဏ်သိက္ခာ/ ဗာ/ ဂုဏ်သိက္ခာ/ ဗာ/ ဂုဏ်သိက္ခာ/ ..

05/06/2019 - 05/06/2019  
05/06/2019 - 05/06/2019  
05/06/2019 - 05/06/2019

מחשבות על חתונה

000-00-00      000/0

ମାମୁଲ ଓ ମିଠାଇ ଓ 5 ଟଙ୍କାର ବିଲ୍‌ବର୍ଦ୍ଧନ + ଟି.ଏସ.ଟି.ଏସ୍ ଓ ମିଠାଇ 8/4 .

தொகுதி தொலைவு  $\propto$  நேரம்



Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2025 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн  
1/2025 дугаар албан бичгийн хавсралт

**“ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БҮЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ,  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР  
ДҮНГИЙН ТАЛААР**

**Нэг. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд  
чиглэсэн бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар;**

*1.1. Урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр  
дүнгийн талаар:*

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжид үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа, дүн шинжилгээнд суурилан эрчимжүүлэх, төрөл мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий “Бодлогын зөвлөл”-ийг байгуулж, “Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу Цагдаагийн байгууллагад харьяалуулсан 16 ажлын салбар төлөвлөгөө, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын төлөвлөгөө”-нд 105 ажил арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр тусгаж, “Бодлогын зөвлөл”-өөс дээрх төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг зохион байгуулалтын хувьд үр дүнтэй болгох үүднээс “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлын төлөвлөгөө”-г мөн гаргаж өнгөрсөн онд нийт 7 удаагийн хуралдааныг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүр холбогдох удирдлага, дээд шатны байгууллагуудад танилцуулж, хэрэгжилт **95** хувь, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт **99.7** хувьтай тус тус дүгнэгдсэн.

Цагдаагийн байгууллагаас 2024 онд “Кибер” болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Залилах” гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 1 бүлэг 6 арга хэмжээ, “Кибер аюулгүй байдлын эсрэг” гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 1 бүлэг 8 арга хэмжээ, нийт 14 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

*Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчны талаар:* Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр логиستيкийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх”-ээр, *Нэгдүгээр үе шат* буюу 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг

Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар албан бичгийн хавсралт

**“ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭЭРГТЭЙ ТЭМЦЭХ,  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР  
ДҮНГИЙН ТАЛААР”**

**Нэг. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд  
чиглэсэн бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар;**

*1.1. Урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр  
дүнгийн талаар:*

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжид үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа, дүн шинжилгээнд суурилан эрчимжүүлэх, төрөл мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий “Бодлогын зөвлөл”-ийг байгуулж, “Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу Цагдаагийн байгууллагад харьяалуулсан 16 ажлын салбар төлөвлөгөө, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлын төлөвлөгөө”-нд 105 ажил арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр тусгаж, “Бодлогын зөвлөл”-өөс дээрх төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг зохион байгуулалтын хувьд үр дүнтэй болгох үүднээс “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлын төлөвлөгөө”-г мөн гаргаж, 2024 онд нийт 7 удаагийн хуралдааныг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүр холбогдох удирдлага, дээд шатны байгууллагуудад танилцуулж, хэрэгжилт **95 хувь**, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт **99,7 хувьтай** тус тус дүгнэгдсэн.

Цагдаагийн байгууллагаас 2024 онд “Кибер” болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Залилах” гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 1 бүлэг 6 арга хэмжээ, “Кибер аюулгүй байдлын эсрэг” гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 1 бүлэг 8 арга хэмжээ, нийт 14 ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

*Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчны талаар:* Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх”-ээр, *Нэгдүгээр үе шат* буюу 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнанас худалдааны байнгын сүлжээг

байгуулна” гэж, мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.1.16-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд “Казиногийн тухай, Хурдын морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулан батлуулах” гэж тус тус заасны дагуу Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүдийг тус яамнаас боловсруулсан.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөлд казино, бооцоот морин уралдаан, бооцоот таавар, хонжворт сугалааг нийтэд нь мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд хамааруулсан бөгөөд эдгээр 4 төрлийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг нөхцөл болон бооцоот таавар, хонжворт сугалаа зохион байгуулах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тусгасан.

Тухайлбал, цахимаар бооцоот таавар зохион байгуулах бол мэдээлэл, технологийн дэд бүтэц нь тасралтгүй, найдвартай ажиллах, аюулгүй байдлыг хангасан байх, Монгол Улсад байршилтэй сервертэй байх, мэргэшсэн хүний нөөцтэй байх зэрэг шаардлагуудыг тавьсан. Харин казиногийн үйл ажиллагаа, бооцоот морин уралдааны үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг тухайлсан хуулиар зохицуулахаар тусгасан.

Түүнчлэн, мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч нь мөрийтэй тоглоомыг шударга ил тод, хариуцлагатай явуулах хонжворыг шударгаар тооцоолж, оролцогчид даруй олгох, нийгэмд үүсгэж болзошгүй сөрөг үр дагавраас сэргийлэх, олон нийтийг мөрийтэй тоглоомд донтохоос хамгаалах зэрэг нийтлэг зарчмыг баримтлахаар зохицуулсан.

Мөн бага насны хүүхдийг мөрийтэй тоглоомын хэрэгсэл болгох нь нийгмийн дэг журамд нийцэхгүй гэж үзэж 14 насанд хүрээгүй хүний оролцсон үйл явдал (уралдаан, тэмцээн)-д бооцоот таавар зохион байгуулах, 18 насанд хүрээгүй хүнийг тоглуулах, мөрийтэй тоглоомыг олон нийтэд сурталчлах зэрэг нийтлэг байдлаар хориглох асуудлыг тусгасан.

Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн хэдий ч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт “ Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасны дагуу тус хуулийн төслүүдийг буцаасанд тооцсон.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгт заасны дагуу тус хуулийн төслүүдэд Засгийн газрын санал, дүгнэлтийг хүргүүлсэн.

*1.2.Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар:*

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах чиглэлээр 2024 онд Улсын хэмжээнд “5Д” нэгдсэн арга хэмжээг төлөвлөж, 5 бүлэг, 41 ажил, арга хэмжээ бүхий “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх таван үйл ажиллагааны хүрээнд цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-г 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулан хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр дүгнэхэд 92.6 хувьтай биелсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/158 дугаар тушаалаар “Дуран” нэгдсэн арга хэмжээний удирдамжийг батлуулж, 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдөр хүртэл 45 хоногийн хугацаатай улсын хэмжээнд зохион явуулсан бөгөөд тус арга хэмжээний явц үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр нэгтгэн дүгнэхэд Цагдаагийн байгууллага 2024 оны эхний 05 сард цахим орчинд үйлдэгдсэн 9107 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсны 449 буюу 4.9 хувийг хаасан, 520 буюу 5.7 хувийг нэгтгэсэн, 710 буюу 7.7 хувийг илрүүлж мөрдөн байцаалтад шилжүүлсэн, 238 буюу 2.6 хувийг шүүхэд шилжүүлж, нийт шалгасан хэргийн 1917 буюу 21 хувийг шийдвэрлэсэн үр дүнтэй ажилласан.

Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулах чиглэлээр Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газраас “Хар сүлжээ” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг хариуцан ажиллах хуваарь, хэлтсийн даргаас алба хаагч нарт өгөх зааварчилга, ирүүлсэн хэрэг, олж тогтоогдсон оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүдийн талаарх мэдээллийг нэгтгэж, албаны удирдлагад танилцуулж, яллагдагчаар татах этгээд нь тогтоогдоогүй хэргүүдийг илрүүлэх, хэрэг бүртгэлтийн хэргүүдийг шийдвэрлэх, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх чиглэлийн ажлуудыг зохион хэрэгжүүлсэн.

Арга хэмжээний хүрээнд 812 хэргийг илрүүлж, оргодол 5, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 32-ыг тус тус олж тогтоосон. Тус арга хэмжээний хүрээнд кибер орчинд залилах гэмт хэрэг үйлддэг сэжигтэй этгээдүүдийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийж ажилласнаар оргодлоор эрэн сурвалжлагдаж байсан 4, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан 10, нийт 14 этгээдийн үйлдсэн 3888 хэрэг, үйлдлийг тогтоож, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах ажлыг зохион байгуулан ажилласан.

Цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа, дүн шинжилгээнд суурилан эрчимжүүлэх, цаашдын чиг хандлага, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, мөн урьдчилан сэргийлэх ажилд дэвшилтэт техник технологи, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлж, төрөл, мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр “Урьдчилан сэргийлэх ажлын 2025 оны үндсэн чиглэл”-ийн тодорхойлж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

*Сургалт, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээний талаар:* Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах”, 20.17 дугаар зүйл “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээлэлд сар бүрээр дүн шинжилгээ хийж, гэмт хэргийг үйлдэж байгаа 30 арга, хэлбэрүүдийг тогтоон зонхилон үйлдэгдэж байгаа “Цахимаар цагийн ажил хийлгэж, мөнгө өсгөх”, “Байр түрээслэх”, “Зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх”,

“Цахим хаягаа хакердуулсан”, “Цахим худалдаа, захиалгатай холбоотой” залилах, “Цахимаар мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргүүд болон улирал, цаг үеийн шинжтэй “Телеграм”, “Романс”, “Монгол шуудан”, “Өвс худалдаалах зар” зэрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, нөлөөллийн ажил, арга хэмжээг тогтмол болон цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан зохион байгуулсан.

Залилах гэмт хэргийн хохирогчдын уг гэмт хэрэгт өртөж хохирох болсон шалтгаан нөхцөлийг судлах зорилгоор иргэд, олон нийтэд нээлттэй Google forms программ ашиглан 15 асуулт бүхий судалгааг боловсруулж, “Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс” цахим хуудсанд байршуулан хамрагдсан иргэдийн судалгааны тайланг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбогдуулан иргэн, хуулийн этгээдийг залилах гэмт хэрэгт өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран “Цахим орчинд үйлдэгддэг залилах гэмт хэргийн онцлог, үйлдлийн арга, урьдчилан сэргийлэх арга зам, хуурамч цахим хаяг, цахим орчны хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөө, цахим орчны зохистой хэрэглээ”, “Хянамгай байя” аянуудыг зохион байгуулсан.

Иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, их, дээд, дунд сургуультай хамтран иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, мэдээллийг түгээх, боловсрол олгох, хор уршгийг таниулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт Ерөнхий боловсролын 13 сургууль, 656 багш, 2.330 эцэг, эх, 128.582 сурагч, 8.705 аж ахуй, нэгж байгууллага, 8.942 оюутан, 6.327 ажилтан, 4.827 малчин, 5.062 ажилгүй иргэд, 14.612 хүүхэд, 8.270 иргэнд сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтад “Цахим мөрийтэй тоглоом”, “Залилах гэмт хэргийн хор уршиг” зэрэг сэдвүүд багтсан.

Мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын алба хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Цахим мөрийтэй тоглоомын хор уршиг, урьдчилан сэргийлэх арга” сэдэвт сургалт, санал асуулга, “Цахим мөрийтэй тоглоом зохион байгуулах, тоглох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтуудыг цагдаагийн байгууллагын цахим сургалтын нэгдсэн систем [esurgalt.police.gov.mn](http://esurgalt.police.gov.mn) динамик платформд байршуулж, сургалтад алба хаагчдаар судлуулсан. Түүнчлэн уг гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж энэ төрлийн гэмт хэргийн хууль эрх зүйн орчин, цагийн үеийн нөхцөл байдал, боловсрол, хор уршгийг таниулах зэрэг урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, зурагт хуудсуудыг тухай бүр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг зах, худалдаа үйлчилгээний төвүүдийн лед дэлгэцэд давхардсан тоогоор 620, цагаан хоолойгоор 256, мэдээллийн самбарт 620, төв орон нутгийн радио, телевизийн эфирээр 279 удаа 638 минутын мэдээ, мэдээлэл буюу 29 удаагийн “Зочны цаг”, ярилцлага, мэдээлэл, сайтын мэдээ, мэдээлэл 89, Монголын Үндэсний Радиотой хамтран 5 төрлийн цуврал нэвтрүүлэг, ярилцлага хийсэн.

Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай уялдуулан “Залилах” болон “Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг”-т иргэдийн өртөн хохирч байгаа шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөмжийн талаар хэвлэлийн бага хурал 2 удаа зохион байгуулж, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон цагдаагийн байгууллагын

албан ёсны цахим хуудсуудаар дамжуулан зурагт хуудас 34, видео мэдээлэл 31, рийлс 21, нийт 209 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 94,186 хүнд таалагдаж, 75,716 хүн бусадтай хуваалцаж, 14,882 хүн сэтгэгдэл илэрхийлж, нийт 11,948,129 цахим хэрэглэгчдэд хүрсэн.

Мөн Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран “Telegram платформ ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх талаар” сэдвийн хүрээнд мэдээллийг бэлтгэж, 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол банк, Кибер аюулгүй байдлын зөвлөл, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэвлэлийн хурлыг зохион байгуулж ажилласан.

Дээрх хэвлэлийн хуралд Монгол улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Харилцаа холбооны зохицуулах хорооны хэвлэлийн албадууд болон хэвлэл мэдээллийн MYOHPT, MongolHD, C1, MN25, UBS, Eagle, TV5, TM, TV9, ETV, Тэнгэр TV зэрэг 11 телевиз, Zogii.mn, MPA.mn, Urug.mn, ASU.mn, Dobu.mn, Eagle news зэрэг 7 мэдээллийн сайт Шууд дамжуулалт хийж, News.mn, Ikon.mn, UBN.mn, Isee.mn, Tug.mn, Dnn.mn, Arslan.mn, Gogo.mn, Itoim.mn, Oper.mn, Zarig.mn, Eguur.mn, Mnb.mn, Check.mn Unuudur.mn зэрэг 34 мэдээллийн сайт нийт 48 хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцож видео, бичвэр, зурагт хуудас хэлбэрээр мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэсэн байна.

Цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг судалгаа, дүн шинжилгээнд суурилан эрчимжүүлэх, цаашдын чиг хандлага, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, мөн урьдчилан сэргийлэх ажилд дэвшилтэт техник технологи, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлж, төрөл, мэргэжлийн албадын ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр “Урьдчилан сэргийлэх ажлын 2025 оны үндсэн чиглэл”-ийн тодорхойлж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

**Хоёр. Хууль бус цахим бооцоот тоглоомын хохирлоос урьдчилан сэргийлэх, талсан зогсоох, хамгаалах, хохирлыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар:** (Гуравдугаар асуулгын утга ижил тул нэгтгэв)

Олон улсад төлбөрт таавар, бооцоот тоглоомын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “1XBET” сайт нь Монгол Улсын хүн амын дунд түгээмэл болсон бөгөөд гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гуйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах гол хэрэгсэл болсон. Иймд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Цахим орчинд “1XBET”-ийг сурталчилж байгаа этгээдүүдэд хариуцлага тооцох, хууль бус сурталчилгаануудыг хязгаарлах, таслан зогсоох, цаашид мөрийтэй тоглоомоос болж иргэд, олон нийтэд хөрөнгө, амь насаараа хохирч байгаа явдлыг бууруулах, таслан зогсоох, бусад төрлийн гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах, мөрийтэй тоглоомыг сурталчлах нь хэвийн мэтээр хэвшсэн ойлголтыг өөрчлөх, учирч болох үр дагавар, хор уршгийг багасгах зорилгоор Монополын эсрэг газар, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагаас 15 этгээдийн мэдээллийг шалгуулахаар Монополын

эсрэг газарт хүргүүлсэн ба үүнээс 1 хуулийн этгээд, 4 иргэнийг 7,000,000 төгрөгөөр торгож, хууль сануулж ажилласан. Мөн энэ төрлийн үйл ажиллагааг бусдад сурталчлахгүй байх талаар Монополийн эсрэг газраар мэдэгдэл гаргуулан төр, хувийн хэвшлийн байгууллагуудад хүргэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос “1XBET” аппликейшн, сайтуудыг Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлах тест хийгдсэн.

Мөрийтэй тоглоом тоглогчдод мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг 110 агентын судалгааг гарган Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг үндэслэн Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран дээрх этгээдүүдийн арилжааны банкууд дахь дансны гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг түдгэлзүүлэн шалгалтын ажиллагаа явуулсан.

Их хэмжээний хууль бус орлого олсон 10 агентад холбогдуулан Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйл (Татвар төлөхөөс зайлсхийх), 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах) ангиудаар хэрэг бүртгэлтийн 10 хэрэг нээн Нийслэлийн прокурорын газрын хяналтад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Татварын ерөнхий газартай хамтран 110 этгээдэд татварын хяналт шалгалт хийж 19 танилцуулга гарч, 25 акт тавигдсан бол 66 агентад шалгалт хийгдэж байна.

Цагдаагийн байгууллагад “1XBET” платформ ашиглан залилсан 309,097,000 төгрөгийн хохиролтой, 689 хэрэг бүртгэгдэн шалгагдсан. “1XBET” сайтын “Агент”-ын үйл ажиллагаа явуулж байгаа иргэд татвар төлөхөөс зайлсхийсэн гэх бүртгэлтийн 10 хэрэгт хохирол, алдсан хөрөнгийн хэмжээг тогтоохоор мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

Иргэдийг цахим гэмт хэрэгт өртөж, хохирохоос сэргийлэх, цахимаар залилуулж алдсан хөрөнгийг хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын тусгай дугаарын 102 утсанд ирүүлсэн Кибер гэмт хэрэгтэй холбоотой дуудлага, мэдээллийг 1040, 1041, 51-265666 тусгай дугаарт хүлээн авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн харьяа дүүргийн прокурорын газрын хяналтын прокурорт танилцуулж “Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах тухай” прокурорын зөвшөөрлийг 24 цагийн дотор гаргуулан, банканд хүргүүлэн хязгаарлалт тогтоон ажиллаж байна.

**Дөрөв. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хохирлын хэмжээ (Сүүлийн 5 жилийн байдлаар)**

| Д/д | Төрөл                                      | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | Нийт  |
|-----|--------------------------------------------|---------|---------|---------|---------|---------|-------|
| 1.  | Залилах /17.3/                             | 1281    | 3858    | 7708    | 7906    | 11711   | 32464 |
| 2.  | Цахим мэдээлэлд хууль бусаар халдах /26.1/ | 145     | 150     | 256     | 383     | 400     | 1334  |
| 3.  | Мөрийтэй тоглоом зохион байгуулах /20.17/  | 18      | 487     | 69      | 373     | 48      | 995   |

|     |                                                                                                |     |     |     |     |     |     |
|-----|------------------------------------------------------------------------------------------------|-----|-----|-----|-----|-----|-----|
| 4.  | Худал мэдээлэл тараах /13.14/                                                                  | 173 | 126 | 124 | 208 | 327 | 958 |
| 6.  | Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших /17.5/           | 17  | 21  | 41  | 53  | 121 | 253 |
| 8.  | Хөрөнгө завших /17.4/                                                                          | 13  | 12  | 29  | 25  | 73  | 152 |
| 10. | Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах /16.8/                                           | 4   | 2   | 37  | 37  |     | 80  |
| 12. | Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах /23.2/                                                    | 3   | 11  | 3   | 10  |     | 27  |
| 14. | Хувь хүний нууцад халдах /13.10/                                                               | 8   | 1   | 2   | 4   | 7   | 22  |
| 16. | Мөнгө угаах /18.6/                                                                             | 1   | 7   |     | 7   | 2   | 17  |
| 17. | Арсен, алмаан, нэгдэл, зэвсэг, хүлээн бэлгийн харилцаанд орох /12.5/                           | 5   | 2   | 1   | 2   | 6   | 16  |
| 18. | Компьютерын мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, борлуулах /26.2/ | 2   | 1   |     | 5   | 1   | 9   |
| 19. | Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах                                            |     |     | 5   | 3   |     | 8   |
| 20. | Хүн худалдаалах /13.1/                                                                         |     |     | 1   | 1   | 3   | 5   |

|     |                        |  |   |   |  |   |   |
|-----|------------------------|--|---|---|--|---|---|
| 22. | Бэлгийн мөлжлөг /12.3/ |  | 1 | 1 |  | 1 | 3 |
|-----|------------------------|--|---|---|--|---|---|

*Хүснэгт 1. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээг сүүлийн 5 жилийн байдлаар*

Цагдаагийн байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд цахим орчинд үйлдэгдсэн нийт 218,549,393,627 (хоёр зуун арван найман тэрбум таван зуун дөчин есөн сая гурван зуун ерэн гурван мянга зургаан зуун хорин долоо) төгрөгийн хохиролтой, 37,258 хэрэг бүртгэгдсэнээс, 88,277,578,118 (наян найман тэрбум хоёр зуун далан долоон сая таван зуун далан найман мянга нэг зуун арван найман) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь нийт хохирлын 40,4 хувийг эзэлж байна.

| Д/д  | Он      | Хэргийн тоон үзүүлэлт | Хохирол         | Хохирол нөхөн төлүүлэлт |
|------|---------|-----------------------|-----------------|-------------------------|
| 2.   | 2021 он | 4802                  | 18,508,685,541  | 9,228,771,541           |
| 4.   | 2023 он | 9212                  | 87,565,252,845  | 38,527,921,227          |
| Нийт |         | 37258                 | 218,549,393,627 | 88,277,578,118          |

*Хүснэгт 2. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээ, хохирол нөхөн төлүүлэлтийн сүүлийн 5 жилийн байдлаар*

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ